



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 1/458

Улаанбаатар хот

Маягт, нөхөх зааврыг батлах,
зөвшөөрөх тухай

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, Үндэсний Статистикийн Хорооны даргын зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Цалин хөлсний статистикийн мэдээллийн дор дурдсан маягт, нөхөх зааврыг 1 дүгээр хавсралтаар баталж, 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй. Үүнд:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын оны -р улирлын мэдээ (Маягт ЦС-1, ЦС-1А, ЦС-1Б, ЦС-2)
2. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалингийн оны -р улирлын мэдээ (Маягт ЦС-3, ЦС-3А, ЦС-3Б);

Хоёр. Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн дор дурьдсан мэдээллийн маягт, нөхөх зааврыг баталж, 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдүүлэхийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам /Төрийн нарийн бичгийн дарга Б. Отгонжаргал/-нд зөвшөөрсүгэй. Үүнд:


1.-ний нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн оны -р сарын тайлан (Маягт НД-7);
2.- д ажиллаж буй даатгуулагчийн оны-р сарын нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт (Маягт НД-8)
- 3.

Гурав. Энэ тушаалаар батлагдсан маягтын үзүүлэлтийн дагуу холбогдох мэдээллийг гарган 2, 5, 8, 11-р сарын 28-ны дотор ҮСХ-нд ирүүлж байхыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Эрдэнэсүвд/-т, цалин хөлсний статистикийн үзүүлэлтүүдийг улсын хэмжээнд нэгтгэн мэдээлж байхыг Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газар /Д.Оюунчимэг/-т тус тус даалгасугай.

Дөрөв. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний статистикийн хорооны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга /Т.Гантөмөр/, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргаа, удирдлагын газар /Г.Нарангэрэл/-т тус тус үүрэг болгосугай.

Тав. Энэ тушаал гарсантай холбогдуулан Үндэсний Статистикийн Хорооны даргын 2012 оны 1/146 дугаар тушаалыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.МЭНДСАЙХАН